



Үндэсний чуулган

**“GSP+ механизмаар дамжуулж хүний эрх,
хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төсөл**

Хэзээ: 2019 оны 5-р сарын 23-24

Хаана: Улаанбаатар хот, Holiday Inn зочид буудал

Үзэл баримтлалын баримт бичиг

Энэхүү үзэл баримтлалын баримт бичиг нь Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Үндэсний чуулганд зориулагдсан болно.

Тус чуулганыг Европын Холбооны санхүүжилт бүхий “GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь” төслийн хүрээнд зохион байгуулж буй. Энэ төсөл нь хүний суурь эрхүүдийг хангуулах зорилгоор нөлөөллийн ажил, мэдлэг дээшлүүлэх арга хэмжээ авч буй иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжихэд чиглэдэг.

Европын холбооны худалдааны механизм болох GSP+ буюу Хөнгөлөлтийн ерөнхий системийн ачаар Армени, Болив, Кабо Верд, Киргиз, Монгол, Пакистан, Парагуа, Филиппин, Шри Ланка гэсэн есөн улс эдийн засгийн урамшуулал хүртэж байна. Гэхдээ GSP+ нь эдийн засгийн урамшуулал олгохын зэрэгцээ хүний эрх, хөдөлмөрийн эрх, байгаль орчин, сайн засаглалтай холбоотой НҮБ-ын 27 конвенцийг дагаж мөрдөхийг тэдгээр орноос шаарддаг. Ялангуяа хүний эрх, ардчиллыг баталгаажсан гэж үзэж болохооргүй өнөөгийн нөхцөлд Хөнгөлөлтийн ерөнхий системийн энэ бүрэлдэхүүн нь ихээхэн хамааралтай. Тэр дундаа хүний эрхийн соёлыг сурталчлах болон хувь хүн, байгууллагыг хүчирхэгжүүлэх бүхий л бололцоог ашиглах нь чухал юм. Монгол Улсад Глоб Интернэшн төв тус хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Оршил

Монгол Улс нь 1992 онд Үндсэн хуулиа баталж хууль эрх зүйн таатай нөхцөл бүрдүүлсэн хэдий ч иргэний болон улс төрийн эрх бүрэн хэрэгжих боломжгүй хязгаарлагдмал, анхаарал татахуйц ноцтой асуудлууд байсаар байна. Түүнчлэн GSP+ механизмд багтах НҮБ-ын 27 суурь конвенцийг соёрхон баталж, хэрэгжилтийг тайлагнах үүргээ хангалттай түвшинд биелүүлж байгаа ч конвенцийн зүйл заалтуудыг хэрэгжүүлэх явцад бэрхшээл учирсаар байна. Монгол Улс ардчиллыг бэхжүүлэхэд анхаарал хандуулж буй боловч хүний эрхийн болон эрх чөлөөний тухай ойлголтын дутмаг байдал, хууль дээдлэх ёс хангалтгүй байгаа нь олон улсын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэхэд саад тотгор болж байна.

Глоб Интернэшнл төв нь GSP+ системд хамрагдах конвенциудаас Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт (ИБУТЭОУП)-ийг буюу ялангуяа пактын 19 дүгээр зүйлийг онцлон ажиллаж үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх орчин нөхцөлийг сайжруулж тус зүйл заалтын хэрэгжилтийг хангахад хувь нэмэр оруулна.



Монгол Улс нь 1974 онд ИБУТЭОУП-ыг соёрхон баталсан боловч иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хараат бус чөлөөт хэвлэлтэй байх эрх чөлөө өнөөг хүртэл зөрчигдсөөр байна. Монгол Улс 2015 онд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит хэлэлцүүлгээр найман орноос үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой зөвлөмж хүлээн авсан. НҮБ-ын Хүний эрхийн хороо 2017 оны долдугаар сарын 6-7-ны өдрүүдэд Женев хотноо болсон 120 дугаар чуулганаараа Монгол Улсын ИУТЭОУП-ын зургаадахь ээлжит тайланг хэлэлцсэн юм. Хүний эрхийн төлөв байдлын илтгэлд болон ИУТЭОУП-ын зөвлөмжид дотоодын хууль тогтоомжоо Пакттай уялдуулж сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангахыг онцолсон.

Монголын улсын Засгийн газрын бодлогод: Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлгээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2016 оны дөрөвдүгээр сар), Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2016 оны арваннэгдүгээр сар) болон Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах, эрх зүйн орчинг сайжруулах амлалтаа биелүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө (2017) багтаж байна. Хэдийгээр дээрх хөтөлбөрүүд хэрэгжиж байгаа боловч төдийлэн хангалттай үр дүнд хүрэхгүй байна. Монгол Улс Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт хэлэлцүүлэг (UPR)-ийн дунд хугацааны тайлангаа 2018 оны тавдугаар сард хүргүүлсэн. Хоёрдахь удаагийн UPR-ийн тайлангийн хугацаа нь 2020 оны 5-р сард товлогдсонтой холбогдуулж Хүний эрхийн ТББ-уудын форумас тайлангаа 2019 оны 9-р сард илгээхээр болсон билээ.

Энэ оны 7-р сард Үндэсний сайн дурын илтгэлээ (ҮСДИ) НҮБ-ын Дээд түвшний улс төрийн чуулганаар хэлэлцүүлэх Засгийн газраас илтгэлээ бэлтгэж байгаатай зэрэгцэн иргэний нийгмээс өөрсдийн сүүдэр илтгэлийг давхар бэлтгэж байна. Тогтвортой хөгжлийн зорилгуудын 1 болон 8 дугаар зорилтууд нь ядуурлыг бууруулж, эдийн засгийн өсөлтийн нэмэгдүүлэх гэдгээрээ GSP+ механизмтай шүүд холбогдож байгаа. Харин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ТХЗ-ын 16.10 дугаар зорилтод (*иргэдийн мэдээлэл олж авах эрхийг хангаж, суурь эрх чөлөөг хамгаална*) багтах бөгөөд тогтвортой хөгжлийг хөдөлгөгч хүч, гол зорилт билээ. Энэ ч утгаараа ТХЗ-ын 16.10 нь 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн зорилгуудын хөтөлбөрийг тэр чигт нь хэрэгжүүлэхэд болон энэ талаарх мэдээллийг олон нийтэд таниулахад чухал үүрэг оролцоотой: Мэдээлэлтэй иргэд л эерэг өөрчлөлтөд чиглэсэн бодит ахицыг шаардах, үүний төлөөх нөлөөлийн үйл ажиллагаанд оролцох боломжтой болно.

Глоб Интернэшн төв нь Free Press Unlimited (FPU), Дойче Вилле академи (DW Akademie) болон ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисстой хамтран Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл олж авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтэд ТХЗ-ын 16.10 дахь зорилтын шалгуур үзүүлэлтээр судалгаа явуулсан юм. Мөн үүнтэй холбогдуулж хоёр өдрийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан бөгөөд энэхүү судалгааны үр дүнгээ Үндэсний чуулганы үер танилцуулах болно.

ҮСДИ нь Монголын нийгмийн хувьд шинэ зүйл бөгөөд тогтвортой хөгжлийн хөтөлбөрт боломж ойлгож буй гэдэг утгаараа GSP+ механизмтай холбогдох шаардлагатай юм.

Үүнээс гадна НҮБ-ын Тусгай илтгэгч Мишель Фрост нь Монгол Улс дахь хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдалтай танилцах ажлынхаа хүрээнд 5-р сарын 1 болон 5-р сарын 8-нд тус Глоб



интернэшнл төв болон Монголын хэвлэл мэдээллийн зөвлөлтэй үүлзсэн билээ. Эдгээр үүлзалтын үеэр сэтгүүлчдийн аюулгүй байдалд хийсэн мониторингийхоо үр дүнг бид хуваалцсан юм.

GSP+ механизмаар дамжуулж хүний эрх, хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих нь төсөл дуусч байгаа бөгөөд Глоб Интернэшнл төвийн төслийн багаас дараах чиглэлээр хэд хэдэн үйл ажиллагаа явуулсан. i) Мэдлэг ойлголтыг дээшлүүлэх; ii) Чадавхжуулах сургалт болон Мониторинг iii) Оролцогч талуудыг үүлзүүлэх.

Төслийн баг мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлаа Улаанбаатар хотод Гарааны семинар зохион байгуулахаас эхэлсэн бөгөөд тус үйл ажиллагаанд МҮХАҮТ, ХЭҮК-ын 21 аймаг дахь төлөөллүүд болон хэвлэл мэдээллийн салбарынхныг оролцуулав. Энэ семинараар GSP+ механизмыг танилцуулахын зэрэгцээ олон улсын суурь конвенциудтай холбогдох асуудлуудын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлсэн билээ. Эдгээр нь оролцогчдын хувьд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19-р зүйлийн талаар мэдлэг хуримтлуулахын зэрэгцээ үүнийг хэрхэн ашиглах талаар чадвар эзэмшүүлэхийн төлөө байсан юм.

Төслийн хоёр дахь бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд бид хэвлэл мэдээлэл болон иргэний нийгмийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсны зэрэгцээ Хэвлэл мэдээллийн гарын авлагыг бэлтгэн гаргасан. Мөн энэ хугацаанд Монголын Хуульчдын холбоо, Монголын хэвлэл мэдээллийг зөвлөлтэй хамтарч сэтгүүлчдийн аюулгүй байдал, хууль эрх зүйн орчинд мониторинг явуулсан бөгөөд 9-р сард өгөх UPR-ийн хоёр дахь циклийн хүрээнд ТББ-уудаас хүргүүлэх тайланд үр дүнг багтаах юм. Үүнийгээ цаашид ч сэтгүүлчдэд зориулсан аюулгүй ээлтэй орчинг бүрдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаанд ашиглах болно.

Харин төслийн гуравдахь бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Архангай, Дархан-Уул, Орхон, Увс, Сүхбаатар, Төв, Баянхонгор аймаг болон Улаанбаатар хотод тус тус Захиргааны танхимын үүлзалтыг зохион байгуулсан ба үйл ажиллагаанд оролцогч талуудын төлөөлөл болсон нийт 270 гаруй хүнийг хамруулсан юм.

Зорилго

Үндэсний чуулган бол төслийн хүрээнд зохиогдох эцсийн үйл ажиллагаа юм. Нэг өдөр хагасын энэхүү үйл ажиллагаагаар төслийн үр дүнг танилцуулж албан ёсоор төслөө өндөрлүүлэх бөгөөд олон янзын оролцогч талуудыг төлөөлөх 60 гаруй хүнийг хамруулах тооцоотой байгаа. Эдгээр оролцогчид нь иргэний нийгмийн мониторингийн тухай болон холбогдох талуудад зориулсан зөвлөмжүүдтэй танилцах төдийгүй цаашдын стратеги төлөвлөгөөнд хувь нэмрээ оруулах болно.

Тодорхой зорилтууд:

- 1) Төслийн үр дүн, гарцын талаар оролцогчдод мэдээлэл өгнө
- 2) GSP+ механизмын суурь конвенциудыг сурталчлах энэхүү санаачлагын хамтын ажиллагааг дэмжих
- 3) Уялдах талуудад зориулсан зөвлөмжүүдээр дамжуулж цаашдын стратегид зориулсан платформуур хангана



Хүлээгдэж буй үр дагавар:

- Монгол Улс дахь хүний эрхийн тулгамдсан асуудлууд болон хэвлэл мэдээлэл, үзэл бодол, мэдээллийн эрх чөлөөний өнөөгийн нөхцөл байдлын талаар мэдлэг ойлголтыг олгосон байх
- GSP+ механизм болон түүний суурь конвенциудыг сурталчлахад ИНБ-үүдэн хүлээн зөвшөөрөгдсөн үүрэг оролцоогоор дамжуулж тухайн механизм нь эдийн засгийн өсөлт хийгээд тогтвортой хөгжлийн хөтөлбөрт ямар үүрэгтэй талаарх мэдлэгийг дээшлүүлсэн байх
- Зөвлөмж болон цаашдын стратегийг бэлэн болгох

Сэдвүүд

Үндэсний чуулганы бүтэц нь дараах гурван загварт багтсан байна:

- Бид юу хийв?
- Одоогоор ямар асуудал байна вэ?
- Цаашид юу хийх вэ?

Эхний загварын хэсэг гэдэг утгаараа Үндэсний чуулганы эхний өдөр нь төслийн амжилт, үр дүнг танилцуулах, мониторингийн дүн хуваалцах болон GSP+ механизмын Монгол дахь ашиглалтын байдлын талаар оролцогч талуудад мэдээлэл олгоход зориулагдана.

Өдрийн хоёр дахь хагаст одоогийн тулгамдаж буй асуудлууд буюу эрүүдэн шүүх, хүүхдийн хүчирхийллийг цаазаар авах ялыг сэргээх шалтгаан болгож буй зэрэг олон нийтийн анхаарлын төвд буй асуудлуудад төвлөрөх болно. Хэлэлцүүлгүүдийн тухайд дотоодын экспертүүдийн мэдээлэл оролцоон дээр үндэслэх юм. Харин үйл ажиллагааны хоёрдахь өдрийн сүүлийн хагаст ТХЗ-ууд, GSP+ болон ҮСДИ уялдаа холбооны тухай панел хэлэлцүүлгүүдээр үргэлжлэх болно. Оролцогчдын хувьд ҮСДИ-ийн үйл явцын талаар мэдээлэлтэй болохын зэрэгцээ GSP+ механизм нь ТХЗ-уудтай хэрхэн холбогдож буй талаарх өөрсдийн үзэл бодол, мэдээллээ солилцох юм.

Компанийн засаглалын салшгүй хэсэг гэдэг утгаар нь хүний эрх, хөдөлмөрлөх эрх төдийгүй Бизнес болон хүний эрхийн үндэсний төлөвлөгөөг бэлтгэх тухай панел хэлэлцүүлгээр сүүлийн өдөр эхлэнэ.

Харин хоёрдахь өдрийн сүүлийн хагаст оролцогчид зөвлөмжүүдийн талаар хэлэлцэх бөгөөд GSP+ механизм, түүний суурь конвенциудыг хөхиүлэн дэмжихэд хэрэглэгдэх цаашдын стратегийн талаар оролцогчид өөрсдийн бодлоо солилцох юм.

Үндэсний чуулганы хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн өргөн хүрээнд сурвалжлахын зэрэгцээ мониторингийн үр дүн, төслийн үр дагаврын талаарх мэдээллийг агуулсан танилцуулгыг түгээх болно.